


Талх Чихэр ХК (TCK.MSE)

Салбар: Аж үйлдвэр

Хувьцааны үнэ



Үнэт цаасны үзүүлэлтүүд

Симбол	TCK
Хувьцааны код	22
Нийт гаргасан хувьцаа (2012 он)	1,023,703
Зах зээлийн үнэ 2012.11.19 (төгрөг)	11,500
Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	11.8
52 долоо хоног- их/бага (төгрөг)	13,999/ 10,500

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	14.47	17.88
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	0.89	0.87
Биет бус хөрөнгө ба өр төлбөр (тэрбум төгрөг)	11.31	13.85
Эзэмшигчийн өмчийн дүн (тэрбум төгрөг)	3.16	4.03
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	871.48	849.61
Үнэ ашгийн харьцаа (P/E)	3.35	13.99
Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B)	0.94	3.02
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.06	0.05
Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE)	0.28	0.22
Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)	80.0	90.0
Ногдол ашгийн өгөөж	0.03	0.01
Дундаж хувьцааны үнэ (төгрөг)	2,919	11,883
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	2.99	12.16
Дансны үнэ (төгрөг)	3,089	3,939
Үнийн хэлбэлзэл	4.84%	6.27%

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Судалгааг бичсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,
Судалгааны багийн ахлагч
chimgee@standardinvestment.mn
Т +976 701 14433
М +976 99066293

Бямба МӨНХТУЯА,
Судалгааны ажилтан
munkhtuya@standardinvestment.mn
Т +976 701 14433
М +976 99027432

КОМПАНИЙН ТОЙМ

Танилцуулга

Талх Чихрийн комбинат нь 1984 онд ЗХУ-ын Засгийн газрын туслалцаатайгаар Улаанбаатар хотод ашиглалтад орсон Монгол Улсын ууган хүнсний үйлдвэрийн нэг юм. 1999 оны 11-р сард хувьчлагдаж, Талх Чихэр ХК болон зохион байгуулагдсан байна. Өдгөө 27 дахь жилдээ 500 гаруй ажиллагсадтай, 60 гаруй нэр төрлийн талх, нарийн боов, бялуу, чихрийн үйлдвэрлэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Менежмент

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Оюунмаа, гүйцэтгэх захиралаар Х.Батцоож ажилладаг байна. Ноён Батцоож нь 1968 онд төрсөн. 1990-1991 онд Ардын Арми дугаар ангид Улс төрийн орлогч, 1991-1992 онд ЦИС-д багш, 1992-2000 ЗЦГ-т төлөөлөгч, 2002-2006 онд Эс энд Ти ХХК-д дэд захирал, Икс Би Жи ХХК-д захирал, 2008 оноос хойш Талх Чихэр ХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.


Хувьцаа эзэмшигчид	Бүтэц
Х.Баттуул	Женко группын ерөнхий захирал 20%
Х.Баттулга	УИХ-ын гишүүн 19%
Ж.Цэндбаяр	Баянгол зочид буудал ХК-ийн гүйцэтгэх захирал 19%
Д.Эрдэнэбилэг	Улаанбаатар банкны ТУЗ-ийн дарга 14%
Бусад (3980 хувьцаа эзэмшигч)	28%

Эх сурвалж: УЦТТХТ


Хамтран ажиллагч байгууллагууд: Женко групп, Ардчилал сонин, Женко Тур Бюро ХК, Мах Импекс ХК, Милл Хаус ХХК, Жи-Эй-Жи ХХК, С1 телевиз, Хиам Консервийн Үйлдвэр, Том Бат ХХК, Чингис Маркет ХХК.

Зах зээлийн мэдээлэл

Одоогийн байдлаар Монгол Улс даяар жижиг том нийт 250 орчим талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр байна. Монгол Улсын нийт талх, жигнэмэг, нарийн боов, чихрийн үйлдвэрлэлийн хэмжээ, аж үйлдвэрт эзлэх хүнсний үйлдвэрлэл болон түүхий эд болох улаан буудайн үйлдвэрлэлийг доорх зургуудад харуулсан болно.



Эх сурвалж: МУ Статистикийн хороо



Эх сурвалж: МУ Статистикийн хороо

Монгол хүний хоол хүнсний хэрэглээнд гурил, гурилан бүтээгдэхүүн зонхилох байрыг эзэлдэг. 1990-ээд онд Монгол Улсын аж үйлдвэрийн салбар 100 хувь төрийн өмчид байсан ба зах зээлийн эдийн засаг руу шилжсэнээр төрийн өмчийн үйлдвэрүүдийн байдал муудаж, 1995 онд боловсруулах аж үйлдвэрлэл ДНБ-д 12 хувийг эзэлж байсан аж үйлдвэрийн салбар, 2004 онд 5 хувь болжээ. Харин хувийн аж үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сайжирснаар 2008 онд энэ тоо 8.3 хувь, 2011 онд 9.2 хувьд хүрсэн байна. Үүнээс хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэлд эзлэх хувь 2005 онд 34 хувь, 2011 онд 38 хувьтай байжээ. 2008 оны Атрын 3 дахь аян хөтөлбөрийн хүрээнд гурилан бүтээгдэхүүний гол түүхийг эд болох буудайн тариалалт ихэсснээр 2005 онд 73.5 мян.тонн улаан буудай үйлдвэрлэж, импортоор 97.5 мян.тонн үр тариа, 103.9 мян.тонн гурил авдаг байсан бол 2011 оны байдлаар дотооддоо 435.9 мян.тонн улаанбуудай үйлдвэрлэж, импортоор 7.4 мян.тонн үр тариа, 67.7 мян.тонн гурил авчээ. Сүүлийн жилүүдэд буудайн тариалалт сайжирсантай холбоотойгоор гурилын үнэ тогтвортой байсан ба мөн Талх Чихэр ХК-ийн “Атар” талхны үнэ 2008-2011 онд 592-645 төгрөгний хооронд хэлбэлзэж байсан бол тээвэр болон бусад хөрөнгө оруулалтын зардлыг тусган 2012 оны 9 сард 840 төгрөг болгон үнээ нэмжээ. Талх Чихэр ХК нь нийт талхны зах зээлийн 80 хувь ба нарийн боовны 40 хувийг дангаараа эзэлдэг байна.

Компанийн өсөлт, хөгжил

Хүнсний ууган үйлдвэрүүдийн нэг болох Талх Чихэр ХК нь 2003 оноос эхлэн техникийн шинэчлэлийг хийж эхлүүлсэн байна. Эдгээрийг дурдвал: 2003 онд Тайван, Япон улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэг хийх урсгал шугам оруулж ирсэн, 2004 онд Европын холбооны улсад үйлдвэрлэсэн “Атар” талх үйлдвэрлэх компьютерийн удирдлага бүхий урсгал шугамыг суурилуулсан. 2005 онд Европын холбооны улсад үйлдвэрлэсэн зууван болон дөрвөлжин хэлбэрийн төрөл бүрийн талх үйлдвэрлэх компьютерийн удирдлага бүхий автомат 2 шугамыг суурилуулсан. 2006 онд Голланд Улсад үйлдвэрлэсэн талхыг зүсэж, уудлах, боох бүрэн автомат ажиллагаатай шинэ тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулж, хэрэглээг анх удаа Монголд бий болгожээ. 2008 онд “Милл Хаус” гурилын үйлдвэрээс “Атар” гурилыг үйлдвэрээс нь шуудайгүйгээр тээвэрлэх тусгай зориулалт бүхий 20 тонны даацтай тээврийн хэрэгслийг Герман, Украин улсад захиалгаар хийлгэж ашиглалтад оруулав. 2010 онд нарийн боовны үйлдвэрийн үйлдвэрлэлийн орчин үеийн техник технологийг 4 тэрбум төгрөгөөр иж бүрэн шинэчилж Чех, Голланд, Итали, БНХАУ-ын нарийн боов үйлдвэрлэх бүрэн автомат ажиллагаатай компьютерийн удирдлага бүхий 2 урсгал шугам суурилуулсан. 2011 онд нарийн боовны үйлдвэрлэлийн шинэ техник технологи ашиглан “зохицуулах үйлчилгээтэй” нарийн боов үйлдвэрлэн худалдаанд гаргажээ. 2012 онд Чех Улсын J4, Moros, Toros зэрэг фирмтэй гэрээ байгуулан зуувин хэлбэрийн талх үйлдвэрлэх шугам нэмж суурилуулан лууван, олон үр, эрдэнэ шиш зэрэг нэмэлт түүхийг эдээр баяжуулсан дөрвөн төрлийн талх худалдаанд гаргасан байна. Ийнхүү 2003 оноос хойш нийт 20 гаруй сая ам.долларын зээлээр хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Мөн үйлдвэрлэсэн

бүтээгдэхүүнүүдээ бүх худалдааны төвүүдээр борлуулдаг байна.

Дүгнэлт

2011 онд Талх Чихэр ХК-ийн борлуулалтын орлого нь 19.8 тэрбум төгрөг, борлуулалтын өртөг нь 16 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлын дүн 2.5 тэрбум төгрөг байж, 2011 онд нийт 0.87 тэрбум төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна. Энэ оны 9-р сард борлуулалтын 80 хувийг эзэлдэг гол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох талхны үнийг ойролцоогоор 30 хувь нэмснээр борлуулалтын орлого нэмэгдэх боломжтой. Өр төлбөрийн (13.5 тэрбум.төг) дийлэнх хэсгийг (11.6 тэрбум.төг) богино хугацаат бусад өглөг буюу гурил бэлтгэн нийлүүлэгч Милл Хаус ХХК-д төлөх өр зээл эзэлжээ. Богино хугацаат өр төлбөрийн хэмжээ 13.8 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгийн хэмжээ 11.1 тэрбум төгрөг байгаа нь санхүүгийн эргэлтийн харьцаа жирийн бус, эргэн төлөлтийн эрсдэлтэй байгааг харуулж байна. Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B) 2010-2011 онд 0.94-оос 3.02 болж өссөн нь хувьцааны үнэлгээ 2011 онд харьцангуй өндөрөөр үнэлэгдсэнийг харуулж байна. Үнэ ашгийн харьцаа (P/E) 2010-2011 онд 3.35-оос 13.99 болж өссөн нь 2011 онд ТСК хувьцааны үнэ харьцангуй өндөр үнэлэгдсэнийг бататгаж байна. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) болон эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE) нь 2011 онд 2010 онтой харьцуулахад багассан нь менежмент сайн байгаагүйг илтгэж байж болно. 2012 оны эхээс өнөөдрийг хүртэл 3.12 хувийн хэлбэлзэлтэй байгаа нь өмнөх 2010, 2011 оныхоос бага хэлбэлзжээ. Харин 2013 оны үйлдвэрлэлд онцгой өөрчлөлт гарч үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдвэл ТСК хувьцааны үнэ өсөх хандлагад орно гэж үзэж байна. Талх Чихэр ХК нь 1993-2011 онуудад 32.3-100 төгрөгний ногдол ашиг олгож байжээ.

Холбоо барих

Хаяг:

Стандарт Инвестмент ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжиджавын гудамж 5/3

Шуудангийн хайрцаг:

Төв шуудан, Улаанбаатар 15160,
Хайрцагны дугаар 1487

Утас: +976 7011 4433

Факс: +976 7011 4433

www.standardinvestment.mn

info@standardinvestment.mn

Мэдэгдэл

Энэхүү судалгааг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд бүх мэдээллийг найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт Инвестмент ХХК нь эдгээр мэдээллийг үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн энэхүү мэдээллийг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт Инвестмент ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү мэдээлэл нь ямар нэгэн үнэт цаасны худалдан авах, худалдах санал буюу хөрөнгө оруулалтын зөвөлгөө биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно. /Стандарт Инвестмент ХХК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Мэдээллийг зөвхөн хаягласан хувь хүн болон албан байгууллагын хэрэглээнд зориулсан ба Стандарт Инвестмент ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр цааш нь дамжуулах, түгээх, хуулбарлахыг хариглоно.

© 2012 Standard Investment LLC